



ОРХОН АЙМГИЙН  
ЗАСАГ ДАРГЫН ДЭРГЭДЭХ ЭРҮҮЛ МЭНДИЙН ГАЗРЫН  
ДАРГЫН ТУШААЛ

2022 оны 07 сарын 07 -ны өдөр

Дугаар А/69

Эрдэнэт

Хөрөнгө гаргах тухай

Монгол улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 67 дугаар зүйлийн 67.5, Төсвийн тухай хуулийн 16 дугаар зүйлийн 16.5, Эрүүл мэндийн тухай хуулийн 11 дүгээр зүйлийн 11.1.5, 11.1.8 заалтыг тус тус үндэслэн ТУШААХ нь:


1. Зорилтот бүлгийн хүн амыг урьдчилан сэргийлэх үзлэгт хамруулах үйл ажиллагааны удирдамжийг нэгдүгээр, үзлэгт шаардагдах төсвийн тооцоог хоёрдугаар хавсралтаар тус тус баталсугай.

2. Зорилтот бүлгийн хүн амыг үзлэгт хамруулах үйл ажиллагааг зохион байгуулж, үр дүнг тайлагнаж ажиллахыг Эх барих эмэгтэйчүүд, хүүхдийн тусламж үйлчилгээ /П.Хишгээ/-д үүрэг болгосугай.


3. Үзлэгт шаардлагатай 1.100.000 /нэг сая нэг зуун мянган төгрөг/-ийг бараа ажил үйлчилгээний бусад зардлаас гаргахыг салбарын санхүү бүртгэл мэдээлэл, нягтлан бодохын ажилтан /Н.Чулуун-Эрдэнэ/-д зөвшөөрсүгэй.

4. Тушаалын хэрэгжилтэнд хяналт тавьж ажиллахыг Хяналт-шинжилгээ үнэлгээ, дотоод аудит хариуцсан мэргэжилтэн /Г.Энхжаргал/-д даалгасугай.

ДАРГЫН АЛБАН ҮҮРГИЙГ ТҮР  
ОРЛОН ГҮЙЦЭТГЭГЧ



Д.СҮХЭЭ



## **Зорилтот бүлгийн хүн амыг урьдчилан сэргийлэх үзлэгт хамруулах үйл ажиллагааны удирдамж**

Үндэслэл: Орхон аймаг нь 105 мянга гаруй хүн амтай, Баян-Өндөр сумын 22 багтай, уул уурхайг дагасан хот бөгөөд хүн амын механик болон цэвэр өсөлт жил бүр нэмэгдэж байна. 2 дахь сум болох Жаргалант сум нь 3200 гаруй хүнтэй, газар тариалан болон мал аж ахуйн чиглэлээр үйл ажиллагаа явуулдаг иргэд ажиллаж амьдарч байна.

2021 оны явуулын үзлэгийн үр шимийг хүртэгсэд нь алслагдсан өрхийн орлого багатай иргэд хамрагдаж нийт давтагдсан тоогоор 1699 хүнд эрүүл мэндийн тусламж үйлчилгээ үзүүлсэн бөгөөд 2 өдрийн үзлэгийг Орхон аймгийн 22 багаар тойрон хийхэд 16-49 насны нөхөн үржихүйн тусламж үйлчилгээ шаардлагатай байгаа эмэгтэйчүүд харьцангуй бага хамрагдсан байна. Иймд дээрхи зорилтот бүлэгт тусламж үйлчилгээг хүргэхийн тулд гэр бүлийн хүрээнд бүх гишүүдэд хүрч үзүүлж чадахгүй байгаа үзлэгийг шигтгээ байдлаар оруулах нь зүйтэй байна. Аймгийн хэмжээнд олон сургалт арга хэмжээ болдог боловч сумын иргэдэд хүрэх хүртээмж мөн бага байна.

2021 онд орлого багатай эмэгтэйчүүд нь урьдчилан сэргийлэх үзлэгт хамрагдсан нийт эмэгтэйчүүдийн 65,3% нь жирэмснээс хамгаалах арга хэрэгслийн талаарх мэдлэг мэдээлэлгүй гэсэн хариулт өгсөн байна. Мөн эмэгтэйчүүдийн 30,9% цэвэршилт тойрны хямралтай, 20%-д умайн хоргүй хавдрын үүсгэвэртэй байсан бөгөөд үзлэгт хамрагдсан эмэгтэйчүүдийн 87,5%- д ганцаарчилсан эрүүл мэндийн боловсрол олгосон байна. Үүнээс хархад эмэгтэйчүүдийн болон нөхөн үржихүйн эрүүл мэндийн боловсролыг тасралтгүй байнгын давтамжтайгаар хүргэх хэрэгтэй байна.

2017-2021 оны эхний хагас жил хүртэлх хугацаанд 7937 жирэмсэн эмэгтэй В,С вирусийн шинжилгээнд хамрагдаж В вирус эерэг 299 буюу 13,7% эерэг, С вирус 77 буюу 10,9% эерэг гарсан. 2020 онд нийт 154 тэмбүү оношлогдсоноос тэмбүүтэй 38 жирэмсэн, 2021 онд 78 тэмбүү оношлогдсоноос 15 жирэмсэн эх эмчилгээнд хавьтагчийн хамт хамрагдсан. Гэр бүл төлөвлөлтөнд хамруулсан хувь- 60,1% байна. 2021 оны байдлаар өсвөр насны охидын жирэмслэлт 2020 онд 4,5% нийт төрөлтөнд, 2021 онд 3,5% болон бирэмсний болон хүүхдээ харж буй 16-19 насны 60 гаруй хүүхэд байна.

Зорилго: Жаргалант сумын иргэдийн дунд эрэгтэйчүүд болон эмэгтэйчүүдийн нөхөн үржихүй, шүд, нүд дотрын өвчний эрт илрүүлэг урьдчилан сэргийлэх үзлэг хийж, эрүүлжүүлэх,

эрүүл мэндийн боловсрол олгох өртөөчилсэн сургалтанд хамруулан нөхөн үржихүйн эрүүл мэндийн боловсрол олгох

Зорилт :

1. Жаргалант сумын төрөх насны эмэгтэйчүүдийг эрүүл мэндийн урьдчилан сэргийлэх дотуур үзлэг, дүрс оношилогоо, умайн хүзүү үтрээний наацын шинжилгээнд хамруулан эмчийн зөвлөгөө өгөх.
2. Гэр бүл төлөвлөлтийн орчин үеийн аргуудыг таниулан зөвлөх үйлчилгээ үзүүлэх сургалт зохион байгуулах .
3. Урологийн эмчийн үзлэг оношилгоо,эмчилгээ, зөвлөгөө болон БЗДХ-ын эрт илрүүлэг үзлэгийг зохион байгуулж, эмчлэн эрүүлжүүлэх арга хэмжээг хэрэгжүүлэх
4. Нөхөн үржихүйн эрүүл мэндийн боловсролыг олгох сургалтанд хамруулах
5. Нүдний өвчний оношилгоо
6. Шүдний эрүүл мэндийн урьдчилан сэргийлэх үзлэг
7. Дотрын эмчийн үзлэг оношилогоо
8. Ерөнхий мэргэжлийн эмчийн үзлэг
9. Сэтгэлзүйчийн сургалт зөвлөгөө

Хамрах хүрээ:Орхон аймгийн Жаргалант сумын алслагдсан багт амьдарч буй иргэд малчид, тариалангийн талбайн ажилчид, сумын суурин иргэд.

Хаана, хэзээ: Жаргалант СЭМТ-н байранд 2022 оны 06 дугаар сарын 15-наас 06 сарын 30-ны өдрүүдэд.

Хамтран ажиллах байгууллагууд:

1. Эрүүл мэндийн газар
2. Сумын эрүүл мэндийн төвүүд
3. Эрдэнэт Медикал эмнэлэг

Хамтран ажиллах байгууллагуудын гүйцэтгэх үүрэг чиглэл

Эрүүл мэндийн газар:

1. Урьдчилан сэргийлэх үзлэгийг ерөнхий удирдлагаар хангах
2. Үзлэгийн дүгнэлт, үр дүнг тооцох, тайлагнах
3. Оношлууруудыг хувиарлах
4. Нарийн мэргэжлийн эмч сувилагч нарын судалгааг ирүүлэх

Сум, ерхийн эрүүл мэндийн төвүүд:

1. Хамрах хүрээний хүмүүстээ урилга хүргүүлэх, үзлэгт хамрагдах иргэдийн судалгаа, чиглэлийг урьдчилан ирүүлэх.
2. Урьдчилан сэргийлэх үзлэг зохион байгуулах байрны бэлэн байдалд хяналт тавих, бэлэн байдлыг хангах.
3. Тоног төхөөрөмж, нарийн мэргэжлийн эмчийн судалгааг ирүүлэх.
4. Үзлэг, сургалт зохион байгуулж буй багийн өдрийн хоол цайг бэлтгэх.



Төрийн бус байгууллага:

1. Сургалтын гарын авлага тараах материалаар хангах
2. Гэр бүл төлөвлөлт, НҮЭМ, БЗДХ/ХДХВ/ДОХ, тэмбүү өвчнөөс сэргийлэх сургалт явуулах.
3. Үзлэгт шаардагдах бараа материал ЖСА хэрэглээгээр хангах

Урьдчилан сэргийлэх үзлэг, эрт илрүүлгийн чиглэл :

1. ЭХО -2
2. Эмэгтэйчүүд
3. Эрэгтэйчүүдийн эмчийн үзлэг оношилогоо зөвлөгөө
4. Нүдний эмчийн үзлэг
5. Шүдний эмчийн үзлэг
6. Дотрын эмчийн үзлэг
7. Ерөнхий эмчийн нэгдсэн дүгнэлт
8. Сэтгэлзүйчийн зөвлөгөө
9. Гэр бүл төлөвлөлт, НҮЭМ- н сургалт
10. БЗДХ-ын эрт илрүүлэг, мазокийн шинжилгээ

Урьдчилан сэргийлэх үзлэг зохион байгуулах хугацаа, байршил: 2022 оны 06 дугаар сарын 15-30-ны өдрүүдэд Жаргалант сумын Эрүүл мэндийн төвийн байранд зохион байгуулна.

Хүлээгдэж буй үр дүн:

1. Эмэгтэйчүүдийн урьдчилан сэргийлэх үзлэг, оношилгоо, эрүүлжүүлэлт хийгдсэн байна.
2. Иргэдийн сэтгэл ханамж нэмэгдэнэ.
3. Малчин, газар тариалангийн ажил хөдөлмөр эрхэлж буй иргэдийн эрүүл мэндийн мэдээлэл зөвлөгөө хүрсэн байна.
4. Гэр бүл төлөвлөлтийн арга хэрэгслийн талаар мэдээлэл сургалт сурталчилгаа хийснээр эмэгтэйчүүд өөрт тохирсон арга хэрэгслийн хэрэглээ нэмэгдсэн байна.
5. Нөхөн үржихүйн эрүүл мэндийн эрхийн талаар тэгш хүртээмжтэй хүрсэн байна.

Эрүүл мэндийн газрын даргын 2022 оны 07... сарын 07  
өдрийн 1/64 тушаалын хоёрдугаар хавсралт



### ШААРДАГДАХ ТӨСВИЙН ЗАДАРГАА

№	Шаардагдах зүйлс	Тоо ширхэг	Нэг бүрийн үнэ	Нийт үнэ
1	Бээлий хос /хайрцаг/	20 хайрцаг	28000₮	560 000₮
2	Мозокын шинжилгээний иж бүрдэл/тавиур шил, бамбар/	50 ш	3000₮	150 000₮
3	Гарын авлагын эх бэлтгэх, хэвлүүлэх ,олшруулах /6 төрөл/	300ш	1333₮	400 000₮
4	Бүгд			1 110 000₮